

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 12 сарын 26 өдөр

Дугаар: 11

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.2, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.9, Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2023 оны 107/53 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Давхар даатгалын компанийн эрсдэлээс хамгаалах санг бүрдүүлэх, байршуулах, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ын 3.1, 3.2, Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгалын багц дүрэм”-ийн 3 дугаар хавсралт “Даатгалын нөөц сан, албан журмын даатгалын сан болон бусад санг бүрдүүлэх, хуваарилах, түүнд хяналт тавих журам”-ын 4.3, 4.4, 4 дүгээр хавсралт “Даатгалын нөөц санд болон албан журмын даатгалын санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ, түүнийг хөрөнгө оруулалтад байршуулахад тавигдах нөхцөл, шаардлага”-ын 2.1, Сангийн сайдын 2017 оны 1 дүгээр тушаалаар батлагдсан “Үндэсний давхар даатгал” ХК-ийн дүрмийн 4.2.3, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 3.3.18-д заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Үндэсний давхар даатгал” ХК-ийн даатгалын нөөц сан, эрсдэлээс хамгаалах сан болон алдагдлаас хамгаалах сангийн хөрөнгийг хөрөнгө оруулалтад байршуулах 2026 оны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Жавхланта)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА



Ч.ТАВИНЖИЛ